



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 21/118

Улаанбаатар хот

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны
газрын эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 31,414,250 (гучин нэгэн сая дөрвөн зуун арван дөрвөн мянга хоёр зуун тавь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Г.Энхтайван)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 6 нэр төрлийн 6,964,600 (зургаан сая есөн зуун жаран дөрвөн мянга зургаан зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн устгах, 12 нэр төрлийн 24,449,650 (хорин дөрвөн сая дөрвөн зуун дөчин есөн мянга зургаан зуун тавь) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулсаны орлогын 30 хувь 28,950 (хорин найман мянга есөн зуун тавь) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Г.Энхтайван)-т, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа санхүүгийн хэлтэс (А.Мөнгөн)-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000218
Улаанбаатар 2021